



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ МАЛЧИН



ИРЭЭД ҮЙ
МИНИЙ ХҮҮ!!!
ИШИГ ХУРГАНЧУДАА
БҮГДИЙГ НЬ ГЭРТ
ОРЧУЛ!!!

ЗА
ААВАА

БАЙЖ БАЙГААРАЙ...
ИШИГ ХУРГАНЧУУД ДУТУУ БАЙНА ЧУ
ДАА?!

ААВАА!
ТӨЛ МАЛЫН
ТОО ДУТУУ
БАЙНА!

ХЭСЭГ МАЛ
СҮРГЭЭСЭЭ ТАСАРСАН
БОЛОЛТОЙ!

ӨӨ.
БАЛАРСАН ЮМ
БОЛОО
ДОО.

!!?!!

МАРГААШ НЬ:

ТЭЭР ЖИЛИЙН
АЙМШИГТ ЗУДНААР БИД
ИХЭНХ МАЛАА АЛДСАН. ААВ
НЬ Ч ЗАЛУУ, ТҮРШЛАГАГҮЙ
МАЛЧИН БАЙЖ ДЭЭ.

ХЭДЭН
БҮЯНТ МАЛЫНХАА
АЧААР АМЬДРАЛ АХУЙ МААНЬ
ӨДИЙ ЗЭРЭГТЭЙ
ЯВНА ДАА...

18 ЖИЛИЙН ДАРАА:

МИНИЙ ОХИН ЧИНЬ
ТИЙМ Л ХҮНД ХЭЦҮҮ ЦАГ
ҮЕЭР ТӨРСӨН ШҮҮ
ДЭЭ...

ОДОО БҮХ ЗҮЙЛ
ӨНГӨРСӨН ШҮҮ ДЭЭ
ААВ. ДАХИЖ БИД НАРТ
ТИЙМ ХҮНД ҮЕ ИРЭХГҮЙ
БАЙХ АА...

ТЭР ҮЕД ХЭРЭВ
ЗУДНААР ХАМАГ МАЛАА
АЛДААГҮЙ, МӨНГӨ ТӨГРӨГ
САЙТАЙ БАЙСАН БОЛ ЭЭЖИЙГ
НЬ ХОТОД ЭМЧЛҮҮЛЭХ
БАЙСАН ДАА...

ЗА ЗА,
МИНИЙ ОХИН ХИЧЭЭЛДЭЭ
ТӨВЛӨР. ААВ НЬ БААХАН
ДЭМИЙ ЮМ ЯРЬЧИЛАА.



ААВАА,
САЙН СҮҮЖ
БАЙВ УУ?





САЙН ЯВЖ
ИРЭВ ҮҮ?
ХҮҮ МИНЬ...
МИНИЙ ХҮҮ ЧИНЬ
ХӨДӨӨ АЖ АХҮЙН
ЯМАР МЭРГЭЖЛЭЭР
ТӨГСӨЖ БАЙГАА
БИЛЭЭ? ААВ НЬ
БҮҮР
МАРТЧИХААД
БАЙХ ЮМ...

БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
ШҮҮ ДЭЭ ААВАА...

ТЭГЭЭД
ОДОО ЯГ ЯМАР
АЖИЛ ХИЙНЭ
ГЭСЭН ҮГ
ҮҮ?

ЕР НЬ БОЛ...
МАНАЙ СУМЫН БЭЛЧЭЭР ЖИЛИЙН
ЖИЛД УЛАМ Л ГАНДАЖ, ДОРОЙТОЖ
БАЙГААГ ТА АНЗААРСАН Л БИЗ ДЭЭ... ХҮҮ НЬ
БЭЛЧЭЭРИЙН ДОРОЙЛЫГ СААРУУЛАХ,
НӨХӨН СЭРГЭЭХИЙН ТӨЛӨӨ Л АЖИЛЛАНА
ГЭСЭН ҮГ.



ТИЙМ ЭЭ
ААВАА. ОЛОН ХҮЧИН
ЗҮЙЛЭЭС БОЛЖ БЭЛЧЭЭР
МААНЬ ДОРОЙТОЖ
БАЙНА.

ҮҮНИЙ НЭГ НЬ
ДЭЛХИЙ ДАЯАР УУР
АМЬСТАЛЫН ӨӨРЧЛӨЛТ
БОЛЖ БИД НАРТ
НӨЛӨӨЛЖ БАЙНА.



ЭЭ ГЯЛАЙ! ХҮҮ МИНЬ НУТАГ
УСАНДАА ХЭРЭГТЭЙ МЭРГЭЖЛЭЭР
СҮРЧЭЭ... СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД
БАЙГАЛЬ ДЭЛХИЙН ЗАН ААШ Ч
ӨӨРЧЛӨГДӨӨД БАЙГАА ШҮҮ. ХЭДЭН
МАЛАА БЭЛЧЭЭХ БЭЛЧЭЭР Ч
ОЛДОХОО БАЙЛАА...



УУР
АМЬСТАЛЫН
ӨӨРЧЛӨЛТ
ӨӨ...?



МАНАЙХ ХАМАГ
МАЛАА АЛДДАГ ТЭЭР ЖИЛИЙН
АЙМШИГТ ЗУДЫН ШАЛТГААН НЬ УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ
ШҮҮ ДЭЭ.

БИ ТАНД ЭНЭ
БҮХНИЙГ ТАЙЛБАРЛАЖ
ӨГЬЕ.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ГЭЖ АГААРЫН ТЕМПЕРАТУР БОЛОН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ УРТ ХУГАЦААНД ӨӨРЧЛӨГДӨХИЙГ ХЭЛДЭГ. АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ХУРДАЦТАЙ ХӨГЖЛИЙГ ДАГААД УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ЭРЧИМЖИЖ БАЙНА. УЛМААР ДЭЛХИЙ МААНЬ

1800 ОНООС ХОЙШ



МАНАЙ УЛСАД:

МОНГОЛ ОРНЫ АГААРЫН ДУНДАЖ ХЭМ 1940 ОНООС ХОЙШ 2,24 ГРАДУСААР НЭМЭГДСЭН.



2015 ОНЫ БАЙДЛААР МОНГОЛ ОРНЫ НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН 76.9% НЬ ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРЙТОЛД ӨРТӨӨД БАЙГАА БА ҮҮНЭЭС ХҮЧТЭЙ, НЭН ХҮЧТЭЙ ЗЭРЭГЛЭЛЭЭР ДОРЙТСОН ГАЗАР 23,1 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА. БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙН 65% НЬ УНАГАН ТӨЛӨВ БАЙДЛААСАА ӨӨРЧЛӨГДӨЖ, ДОРЙТСОН БАЙНА.

АГААРЫН ДУНДАЖ ХЭМ НЭМЭГДЭХЭЭС ГАДНА ЖИЛИЙН НИЙТ ХҮР ТУНАДАСНЫ ХЭМЖЭЭ 7%-Р БУУРСАН БАЙНА. УУРШИЛТ НЭМЭГДЭЖ, ЗУНЫ ЧЛИРЛЫН ХҮР ТУНАДАСНЫ ХЭМЖЭЭ БАГАССАНЫ УЛМААС ЖИЖИГ ГОЛУУД, БУЛАГ ШАНД, НУУР ЗУНЫ ГАЧИГ ҮЕД ТАСАРЧ, ХАТАЖ БАЙНА.



ИЙНХҮҮ ХЭТ ХАЛУУН ӨДРИЙН ТОО СҮҮЛИЙН 45 ЖИЛИЙН ДОТОР 24 ӨДРӨӨР НЭМЭГДЭЖ, НИЙЛБЭР ХҮР ТУНАДАС БУУРСНЫ УЛМААС ЭРС ТЭС БАЙДАЛ, ХУУРАЙШИЛ НЭМЭГДЭЖ, ГАН ЗУДЫН ДАВТАГАЛ, ЭРЧИМ НЭМЭГДЭХ НӨХЦӨЛИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙНА. СҮҮЛИЙН 20 ЖИЛД БАЙГАЛИЙН АЮУЛТАЙ ҮЗЭГДЛИЙН ДАВТАГАЛ 2 ДАХИН НЭМЭГДЭЖ, ЖИЛД ДУНДЖААР 54 УДАА АГААР МАНДЛЫН ГАРАЛТАЙ АЮУЛТАЙ БОЛОН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ ТОХИОЛДОЖ БАЙНА.



УУР АМЬСТАЛЫН
ӨӨРЧЛӨЛТ МАНАЙ
НУТАГТ УЛАМ БҮР
МЭДРЭГДЭХ БОЛСОН.
ЗУНДАА ХЭТ ИХ ХАЛЖ,
ХУУРАЙШИЖ, ГАН ГАЧИГ
БОЛЖ БАЙНА.




ЗӨӨЛӨН ШИВРЭЭ БОРОО
ОРОХОО БОЛЬЖ, ОЙР ОЙРХОН
ШИРҮҮН УСАРХАГ ААДАР БОРОО
ОРСНЫ УЛМААС ҮЕР БОЛЖ,
ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМ Ч
МҮҮДСАН.



ХАМГИЙН ГОЛ НЬ
ЭНЭ ӨВӨЛ ЯГ ӨМНӨХТЭЙ
АДИЛ АЮУЛТАЙ ЗУД
БОЛНО.

ЗУНДАА
ГАН ГАЧИГТАЙ УЧРААС
БЭЛЧЭЭРИЙН ХОМСДОЛД ОРЖ,
ӨВӨЛ НЬ ЦАС ИХ ОРСНООС
ЗУД БОЛНО ШҮҮ ДЭЭ.

БИД БАЙГАЛЬ
ДЭЛХИЙН АРАНШИНГ ТАНИН МЭДЭЖ,
БЭЛЧЭЭРЭЭ ЗОХИСТОЙ АШИГЛАДАГ
УЛАМЖЛАЛТ МАЛ МАЛЛАХ АРГА УХААНТАЙ
АРД ТҮМЭН ГЭТЭЛ ЗӨВХӨН МАЛЫН ТООГОО
НЭМЭГДҮҮЛЭХ ГЭЭД ЗҮТГЭСЭЭР БАЙВАЛ
ХЭДХЭН ЖИЛИЙН ДАРАА ЭНЭ НУТАГТАА
АМЬДРАХ БОЛОМЖГҮЙ БОЛОХ ГЭЭД
БАЙНА ААВАА.



МАРГААШ НЬ:

ИРЭЭДҮЙ ХҮҮ СУДАЛГАА ХИЙСЭН БӨГӨӨД ТЭР ХАВИЙНХАА
МАЛЧДЫГ ЦУГЛУУЛЖ ТАНИЛЦУУЛНА



МАНАЙХААН
БИД УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН
ЗОХИЦОЖ, БЭЛЧЭЭРЭЭ ЗҮЙ
ЗОХИСТОЙ АШИГЛАХ
ХЭРЭГТЭЙ



ЭНЭ БОЛ
МИНИЙ ХИЙСЭН СУДАЛГААНЫ
ЗУРАГНУУД. ЭНДЭЭС ЖИЛЭЭС
ЖИЛД МАНАЙ НУТАГТ БЭЛЧЭЭРИЙН
ДААЦ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА НЬ ХАРАГДАНА.



ЭНЭ БОЛ
ХОЁР ЖИЛИЙН
ӨМНӨХ ЗУРАГ.



ЭНЭ БОЛ ЭНЭ САРД
АВСАН БЭЛЧЭЭРИЙН ЗУРАГ. ИЙМ
БОГИНО ХУГАЦААНД БЭЛЧЭЭР
ХЭРХЭН МҮҮДСАН БАЙГААГ
ХАРЖ БОЛНО



ЛӨӨХ, НЭЭРЭЭ
ИЙМ САЙХАН ГАЗАР
БАЙСАН БИЛҮҮ

БЭЛЧЭЭРЭЭ
БИД ТАЛХАЛЖ
ОРХИЖЭЭ

ОДОО ТЭГЭЭД
БЭЛЧЭЭР МААНЬ
ХУУЧИН ХЭВЭНДЭЭ
ОРОХ БОЛОВ ЧҮ.



БЭЛЧЭЭР МААНЬ
ЭРГЭН СЭРГЭЭГДЭХ
БОЛОМЖТОЙ.

ХАРИН СЭРГЭЭХИЙН
ТУЛД БИД ЧҮР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ,
БЭЛЧЭЭРЭЭ ХАМГААЛАХ МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ
ХЭРЭГТЭЙ

ЗА ТЭГВЭЛ,
БЭЛЧЭЭР НУТГАА
ХАМГААЛЖ СЭРГЭЭХЭД
НЭГДЭН "БАЙГАЛЬД
ЭЭЛТЭЙ" МАЛЧИН БОЛОХ
ХҮМҮҮС ГАРАА
ӨРГӨНӨ ҮҮ.



ХЭСЭГ ХУГАЦААНЫ ДАРАА:



ОДОО БИД ЦАГ ҮЕТЭЙГЭЭ
ЗЭРЭГЦЭЖ ЯВАХЫН ТУЛД МЯНГАТ
БИШ "БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ" МАЛЧИН
БОЛОХОД АНХААРАХ ХЭРЭГТЭЙ.
ТИЙМЭЭС ТА МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГАД НЭГДЭЭРЭЙ.

БИД МАЛЫН
ТОО БИШ ЧАНАРТ НЬ АНХААРЧ
ЦААШЛААД, ЧАНАРТАЙ МАЛЫН
ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ЗАХ ЗЭЭЛД БОРЛУУЛЖ ОРЛОГОО
ӨСГӨХӨӨР АЖИЛЛАЖ
БАЙГАА...



ХЭСЭГ ХУГАЦААНЫ ДАРАА:



ҮГҮЙ ЭЭ. МАЛЫН ТООГОО
БАГАСГАЧИХААР ЧИНЬ ЯАЖ АШИГ
ОЛОХ ВЭ ДЭЭ. МАНАЙ ХҮҮ ХАРИН
НЭГ ТИЙМ БҮТЭХГҮЙ ЗҮЙЛ ЯРИАД
ЯВААД БАЙГАА ЮМ.

ХАРИН НЭЭРЭЭ ЭНЭ ӨВӨЛ
АЮУЛТАЙ ЗУД БОЛНО ГЭСЭН
ШҮҮ. МАЛЫН ТООГОО ИХЭСГЭХГҮЙ
БОЛ ЗУДНЫ ДАРАА **ХЭЦҮҮДНЭ
ШҮҮ!**



ХЭСЭГ ХУГАЦААНЫ ДАРАА:



ПҮНЦАГ ГУАЙ,
БЭЛЧЭЭРЭЭ ЗҮЙ ЗОХИСТОЙ
АШИГЛАЖ, 4 УЛИРАЛДАА БЭЛЧЭЭР
СЭЛГЭН НҮҮДЭГ УЛАМЖЛАЛТ
МАЛЧИН АХУЙ МААНЬ АЛДАГДАЖ
БАЙНА

ТА МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГАД ЭЛСЭЖ, БЭЛЧЭЭР
НУТГАА ХАМГААЛАХАД БИДЭНТЭЙ
НЭГДЭЭРЭЙ. ҮГҮЙ БОЛ ЧДАХГҮЙ БИД
БЭЛЧЭЭРГҮЙ БОЛЖ НУТГААСАА
НҮҮХЭД ХҮРНЭ ШҮҮ...



ХЭСЭГ ХУГАЦААНЫ ДАРАА:



ТЭР
МАЛЧДЫНХ НЬ
БАЙГУУЛЛАГАД НЭГДЭЖ
ЦАГАА ҮРЭХ ХЭРЭГ БАЙНА
УУ? ПҮНЦАГ МИНЬ. ХӨГШИН
ХҮН ОЙР ОЙРХОН НҮҮХ
ХЭЦҮҮ БИЗ ДЭЭ...



ИРЭЭДҮЙ ХҮҮ
МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГЫН
ГИШҮҮДИЙГ
ЦУГЛУУЛАВ.

БЭЛЧЭЭР
АШИГЛАЛТЫН
ДҮРЭМ

БИ ТА БҮХЭНД
БЭЛЧЭЭР АШИГЛАХ
АЛТАН ДҮРМИЙГ
ТАНИЛЦУУЛЪЯ.



ТА БҮХЭНДЭЭ
БЭЛЧЭЭР АШИГЛАХ АЛТАН
ДҮРМИЙГ ТАНИЛЦУУЛЖ
БАЙНА. ДҮРЭМ ДӨРВӨН
ҮНДСЭН ЗАРЧМААС
БҮРДЭНЭ.



1. БЭЛЧЭЭРИЙН ДААЦ

БЭЛЧЭЭРИЙН ДААЦЫГ
ХЭТРҮҮЛЖ БОЛОХГҮЙ.
МАЛЫН ТООГОО
БЭЛЧЭЭРИЙН ДААЦТАЙ
НИЙЦҮҮЛЭХ.

2. ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ

МАЛЫН ТЭЖЭЭЛЭЭ
БОЛОЛЦООНЫХОО
ХИРЭЭР БЭЛГЭЖ СҮРАХ
ХЭРЭГТЭЙ.



БЭЛЧЭЭРИЙН
АЛТАН ДҮРЭМ

ДҮРЭМ 1

ДҮРЭМ 2

ДҮРЭМ 3

ДҮРЭМ 4



3. БЭЛЧЭЭРИЙН УРГАМАЛ

БЭЛЧЭЭРИЙН УРГАМАЛД
ТӨЛЖИН УРГАХ
БОЛОМЖИЙГ ОЛГОЖ
БАЙГААРАЙ.

4. БЭЛЧЭЭР СЭЛГЭХ

ТӨЛЖИХ ХҮГАЦАА МАШ
ИХ ХЭРЭГТЭЙ БАЙДАГ.
БЭЛЧЭЭРЭЭ СЭЛГЭН
АМРААЖ БАЙХ
ХЭРЭГТЭЙ.

МАЛЧИД БЭЛЧЭЭР АШИГЛАХ ДҮРМИЙГ ЗӨВШӨӨРСӨН УЧРААС ИРЭЭДҮЙ ХҮҮ МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГЫН МАЛЧИДАЙГАА БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХААР БОЛЛОО.

ГЭРЭЭНД
ОЙЛГОХГҮЙ
ЗҮЙЛ БАЙВАЛ
АСЧУГААРАЙ.

ЗА

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ

- МАЛЫН ТОО ТОЛГОЙГ БЭЛЧЭЭРИЙН ДААЦАД НЬ ТОХИРЧУЛАХ.
- УРТ УДААН ХУГАЦААНД ТОГТВОРТОЙГООР ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ.
- ХЭДЭН ҮЕЭРЭЭ БЭЛЧЭЭРЭЭ ХАМТРАН АШИГЛАЖ ИРСЭН МАЛЧДЫН УЛАМЖЛАЛТ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ.
- ХАВСРАЛТ 1 - МАЛЧИН ӨРХИЙН НАСАНД ХҮРСЭН ЭРЭГТЭЙ ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН ГАРЫН ҮСЭГ.
- ХАВСРАЛТ 2 - БЭЛЧЭЭРИЙН УЛИРЛЫН БАЙРШИЛ, ДААЦ, АЧААЛЛЫН ТООЦОО, ЗУРАГ.
- ХАВСРАЛТ 3 - БЭЛЧЭЭРИЙН ЭКОЛОГИЙН ЧАДАВХЫН ЗУРАГЛАЛ.
- ХАВСРАЛТ 4 - БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ШИЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН ТҮВШИН.

БЭЛЧЭЭРЭЭ
СЭРГЭЭХ, НУТАГ
УСАА ХАМГААЛАХАД
БИДЭНТЭЙ НЭГДЭН
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН
ТА БҮХЭНДЭЭ
БАЯРЛАЛАА.

БҮГДЭЭРЭЭ БЭЛЧЭЭР
АШИГЛАЛТЫН ДҮРМЭЭ
БАРИМТАЛЖ АЖИЛЛАХАА
ЭНЭ ГЭРЭЭГЭЭР
БАТАЛГААЖУУЛАА

ЭНЭХҮҮ ГЭРЭЭ БАЙГУУЛАГДСАНААР МАЛЧИД ХЭСЭГ
ХЭСГЭЭРЭЭ БЭЛЧЭЭРЭЭ СЭЛГЭН НҮҮДЭЛЛЭЖ ЭХЭЛЛЭЭ.



БЭЛЧЭЭРИЙН ДААЦДАА НИЙЦҮҮЛЭН МАЛЫН ТОО ТОЛГОЙГ ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭНД
БАРЬЖ ЦӨӨХӨН МАЛААС ӨНДӨР АШИГ ШИМ АВАХАД МАЛЧИН БҮР АНХААРАВ.



МАЛЧИД БЭЛЧЭЭРЭЭ ХАМГААЛЖ, ЗҮЙ ЗОХИСТОЙГООР
АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ. БЭЛЧЭЭРИЙН ТАЛХАГДАЛ Ч БАГАСАВ.



ДАРАА НЬ: МАЛЧИД ДУНДЫН МӨНГӨН ХУРИМТЛААЛ ҮҮСГЭВ



МАНАЙ МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮД ЭЭ. УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ДАСАН
ЗОХИЦОХ АЖЛУУД МААНЬ
ЭХНЭЭСЭЭ ҮР ДҮНГЭЭ
ӨГЧ БАЙНА.

БЭЛЧЭЭРЭЭ
ХАМГААЛЖ СЭЛГЭН
НҮҮСНИЙ АЧААР
БЭЛЧЭЭРИЙН УРГАМАЛ
СЭРГЭЖ БАЙНА.

ОДОО
ХАРИН ӨӨР
ХИЙХ АЖЛЫН
САНАЛ БАЙВАЛ
ХЭЛЭЭРЭЙ.

САЙН БАЙНА УУ?
БЭЛЧЭЭРИЙН БОЛОН ГАЗАР
ТАРИАЛАНГИЙН УСАН
ХАНГАМЖАА НЭМЭГДҮҮЛЭХ
ХЭРЭГТЭЙ БАЙНА. ХЭДИЙ
БЭЛЧЭЭР СЭРГЭЖ БАЙГАА Ч
ГАН ГАЧИГ БОЛЖ
БОЛНО ШҮҮ ДЭЭ.

МАЛЫН ХАЛДВАРТ
ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ХЭРЭГТЭЙ
БАЙНА.

ТЭЖЭЭЛИЙН
УРГАМАЛ ТАРИАЛАХГҮЙ
БОЛ ГОРЬГҮЙ НЬ НЭЭ.
ӨВӨЛ ЗУД БОЛОХОД
БИДЭНД ТЭЖЭЭЛИЙН
НӨӨЦ ХЭРЭГТЭЙ.

ТА БҮХНИЙ
САНАЛЫГ
ОЙЛГОЛОО...

МАРГААШ
ЗАСАГ ДАРГААР
БАТЛУУЛЖ ЭНЭ
АСЧУДЛУУДЫГ
ШИЙДЬЕ.


МАРГААШ НЬ: ИРЭЭДҮЙ МАЛЧДЫНХАА САНАЛЫГ ЗАСАГ ДАРГАД ТАНИЛЦУУЛАВ.



ЗАСАГ ДАРГА ИТХ-ААР МАЛЧДЫНХАА САНАЛУУДЫГ ТАНИЛЦУУЛАН БАТЛУУЛЛАА.



ТӨСӨВ Ч ОРЖ, ЭХНЭЭСЭЭ АЖЛУУД ХИЙГДЭЖ ЭХЛЭВ



ШИНЭ ХУДАГ ГАРТАЖ, ХУУЧИН ХУДГУУДАА СЭРГЭЭН ЗАСВАРЛАВ.



МАЛЫН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ВАКЦИНЖУУЛАВ. МӨН МАЛ СҮРГИЙГ ШИМЭГЧЛЭХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ УГААЛГЫН АЖЛЫГ ХИЙВ.



МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ХОЛИМОГ НЬ МАЛЫН АШИГ ШИМИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ТҮСТАЙ БАЙДАГ УЧРААС НОГООН ТЭЖЭЭЛ ТАРИАЛАВ.

МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

МАЛ СҮРГИЙГ ЖИЛ БҮР ТОГТМОЛ УГААЛГА, ТУУЛГАЛТАД ХАМРУУЛСАНААР ШИМЭГЧ ХОРХОЙН ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, АРЬС ШИР, НООС, НООЛУУР, МАХНЫ ГАРЦ ЧАНАР ДЭЭШИЛДЭГ НЬ СУДАЛГААГААР ТОГТООГДСОН БАЙНА. ШИМЭГЧ ХОРХОЙН ӨВЧЛӨЛГҮЙ БОЛШНООР МАЛЫН ТАРГА ТЭВЭЭРЭГ НЭМЭГДЭЖ, МАХНЫ ГАРЦ 20 - 30% ӨСДӨГ.

ХЭДЭН САРЫН ДАРАА ИРЭЭДҮЙ ХҮҮГИЙН НУТАГТ ГАН БОЛОО.



ЗАРИМ МАЛЧИД НУТАГ СЭЛГЭН НҮҮХЭД ХҮРЛЭЭ. МАЛЧИД ОТОР ХИЙХ НЬ БЭЛЧЭЭР БУЛААЦАЛДАХ, МАЛ ИДЭЭШИХГҮЙ БАЙХ... ЗЭРГЭЭР ОЛОН АСУУДЛЫГ ДАГУУЛАХ БОЛОВ.



МАЛ Ч ОЛИГТОЙ ТАРГА АВСАНГҮЙ. БОРЛУУЛАХ ГЭХЭЭР ОЛИГТОЙ ҮНЭД Ч ХҮРЭХГҮЙ НЬ ДЭЭ




ЭНЭ ҮЕД:


МАЛЫНХАА ТООГ ЦӨӨРҮҮЛЭН, ЧАНАРТ АНХААРЧ, ӨӨРТӨӨ ТААРСАН ШАГ ХИЙСЭН МАЛТАЙДАА ЭНЭ ХЭЦҮҮ ГАН ГАЧГИЙГ ДАВГУЙ ДАВЖ БАЙНА ШҮҮ

ХАРИН ТИЙМЭЭ ХӨ. МАНАЙ ИРЭЭДҮЙГИЙН ААВ Л ХЭЦҮҮДЭЖ БАЙГАА БАЙХ ДАА





ОДОО
ЭНЭ ХЭДЭН
ТУРАНХАЙ МАЛ МААНЬ
ТАРГА ТЭВЭЭРЭГ АВАХГҮЙ
БАЙСААР ӨВӨЛТЭЙ
ЗОЛГОХ НЬ ДЭЭ
ХӨӨРХИЙ



ЗА ААВ МИНЬ
ОРЖ АМАР ДАА.
ХҮҮ НЬ УЧРЫГ НЬ
ОЛНО ОО. АЛИВАА
ЗҮЙЛД ГАРЦ
БАЙГАА.

1 САРЫН ДАРАА...



ГАН ТАЙЛАГДСАНЫ ДАРАА МАЛЧДЫН
БАЙГУУЛЛАГАД МАЛЧИД ШИНЭЭР НЭГДЭВ.


СУМЫН ЗАХИРГАА



БАЙГУУЛЛАГАД
МААНЬ ШИНЭЭР ОРСОН
МАЛЧИДДАА ХАМГИЙН
ГОЛ ХЭЛЭХ ЗҮЙЛ БОЛ
ЕРӨӨСӨӨ ТОО БИШ
ЧАНАР ШҮҮ.


МЯНГАТ БИШ
"БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ"
МАЛЧИН БОЛЖ УУР
АМЬСТАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
ДАСАН ЗОХИЦОХ
ХЭРЭГТЭЙ.

ТИЙМЭЭС
МАЛЫНХАА ТООНД
БИШ, ЧАНАРЫГ
АНХААРААРЙ.



ОДОО
УДАХГҮЙ
ӨВӨЛ
БОЛОО.

ӨВӨЛЖИЛТИЙН
БЭЛТГЭЛЭЭ БАЗААЖ,
МАЛЫНХАА ЧАНАРЫГ
АНХААРСАН БАЙХАД БИД
ЗУДТАЙ ӨВЛИЙГ
ХАМТДАА ДАВЖ
ЧАДНА АА.





ААВАА!
ЭНЭ БОЛ
"ХАРИУЦЛАГАТАЙ
НҮҮДЭЛЧИН"
СТАНДАРТ.

ЭНЭ НЬ
МАЛ АЖ АХУЙН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ТОГТВОРТОЙ
ЯВУУЛАХАД ТАНД
ТУСАЛНА.

ЗА БАЙЗ.
ТЭГЭХЭЭР
ЯНАН ГЭСЭН
ҮГ ВЭ?

БЭЛЧЭЭРИЙН ЭРҮҮЛ БАЙДАЛ

НЭГДҮГЭЭРТ: ТА БЭЛЧЭЭРЭЭ СЭЛГЭХ ХЭРЭГТЭЙ.
МАЛЫНХАА ТООГ БЭЛЧЭЭРИЙН ДААЦААС
ХЭТРҮҮЛЖ БОЛОХГҮЙ.



ХАВАРЖАА
ЗУСЛАН
НАМАРЖАА
ӨВӨЛЖӨӨ

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД

ТА МАЛЫНХАА ӨВЧЛӨЛД АНХААРЧ УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТОГТМОЛ ХАМРЧУЛЖ
БАЙХ ХЭРЭГТЭЙ.

МАЛЫН ТАВЛАГ БАЙДАЛ

МАЛЫН ТАВ ТУХТАЙ БАЙДАЛ. МАЛЫНХАА ХАШАА
ХОРООГ БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ МАТЕРИАЛААР БАРИХ
ХЭРЭГТЭЙ. ӨТӨГ БУЦЦАА ТОГТМОЛ ХУУРАЙ БАЙЛГАЖ,
МАЛ УНДААЛАХ ҮС ӨВӨРМӨЦ ӨНГӨ ҮНЭР,
АМТГҮЙГЭЭС ГАДНА ХОРТ ХОЛЬЦГҮЙ, ЦАГААН ХОРХОЙ,
ТЭДГЭЭРИЙН АВГАЛДАЙ ЗЭРГЭЭР БОХИРДООГУЙ
БАЙХ НЬ ЧУХАЛ. ХУДАГ, УСНЫ ОНГОЦОО БҮХЭЛД НЬ
ЦЭВЭР БАЙЛГАЖ, БАЙНГА ШАЛГАЖ БАЙГААРАЙ.



ХУУЧИРЧ МУУДСАН ТЭЖЭЭЛ АШИГЛАЖ БОЛОХГҮЙ.
БЭЛТГЭСЭН ӨВСӨӨ ЧИЙГҮЙ ГАЗАР ХАДГАЛЖ, ШИНЭ
ӨВС, ТЭЖЭЭЛЭЭ ХУУЧИНТАЙГАА ХОЛИХГҮЙ БАЙХ.
САЛХИ ШУУРГА, ЦАС ЗУДТАЙ ӨВӨЛ, ХАВАР МАЛ
БЭЛЧЭЭРЛЭХ БОЛОМЖГҮЙ ҮЕД САЙН ЧАНАРЫН
ТЭЖЭЭЛ, ХАДЛАН ӨВС, ХУЖИР ХЭРЭГЛЭХ.

МАЛЫНХАА ТАРГА ТЭВЭЭРЭГТ НЬ АНХААРЧ, ЯМАР НЭГ ӨВЧИН ХАЛДВАРГУЙ, ЭРҮҮЛ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХЭД АНХААРАХ ХЭРЭГТЭЙ. МӨН НООЛУУРАА САМНАСНЫ ДАРАА ӨНГӨ, ЧАНАРААР НЬ АНГИЛЖ, ТООСНООС ХАМГААЛААРАЙ.



ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН




ТА ЮУНЫ ӨМНӨ "МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГА" -ЫН ГИШҮҮН БАЙХ ЁСТОЙ. МӨН ӨНӨӨ ЦАГТ ҮЙЛДВЭРҮҮД ТҮҮХИЙ ЭД ИХ ХЭМЖЭЭГЭЭР ТОГТМОЛ АВАХ СОНИРХОЛТОЙ БОЛСОН ТУЛ ТА АШИГТАЙ АЖИЛЛАЖ БОЛНО. ҮҮНИЙ ТУЛД ТА ТҮҮХИЙ ЭДИЙГ ТОГТВОРТОЙ, ЧАНАРТАЙ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ.

БАЙГАЛЬ ОРЧИН

БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙД БАЙГАА ГОЛ ТҮЛХҮҮР ЗҮЙЛ БОЛОХ УРГАМЛЫН БҮРТГЭЛ ЖАГСААЛТЫГ ТОГТМОЛ БҮРТГЭЖ БАЙГААРАЙ. БЭЛЧЭЭРЭЭ СЭЛГЭХ НЬ БЭЛЧЭЭР НӨХӨН СЭРГЭХЭД ТУС ДЭМ БОЛНО





МИНИЙ ОХИН
ХОНИО САЙН ХАШСАН БИЗ.
ХААЛГА НЬ ОНГОЙГООД
ГАРААД ЯВЧИХ ВИЙ?



ХАШСАН
ААВ АА. БҮГДЭЭРЭЭ
ЭНЭ ӨВЛИЙГ ӨНТЭЙ
ДАВАХ НЬ ЭЭ.

МИНИЙ
ОХИН АМ ГАРЧ
БОЛДОГҮЙ
ЮМ.



ХАВАР: БАТБӨХ, ИРЭЭДҮЙ ХОЁР ТҮҮХИЙ ЭД, МАХ,
СҮҮГЭЭ БОРЛУУЛАХААР ЯВЛАА




ТЭР ХОЁР ХАМТДАА НЭГЭН ЧЕНЖ ДЭЭР ОЧИВ



ТАНАЙ
ТҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮН ДАЖГҮЙ
Л ЮМ. ГЭХДЭЭ ҮНЭ
НЭМЖ АВЧ ЧАДАХГҮЙ НЬ
ЭЭ. .. ӨМНӨ НЬ АВДАГ
БАЙСАН ҮНЭЭРЭЭ Л
АВЬЯ...

ЭНЭ
ЯМАР САЙН
АРЬС ВЭ? БИ
АВЬЯ.



САЙХАН
ТАРГАН МАХ БАЙХ
ЧИНЬ. БҮГДИЙГ НЬ
АВЬЯ. ХЭДЭЭР
ӨГӨХ ВЭ?

ЗА ЗА.
АЛИВ САЯ
ХЭЛСЭН ҮНЭЭР
ЧИНЬ АВЬЯ.



МАЛЫНХАА ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ИНГЭЖ
ХУРДАН БОРЛУУЛААД БАЙВАЛ
МУУ ОХИНЫХОО СУРГАЛТЫН
ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХӨД АМАР
БОЛОХ НЬ ЭЭ.





МОНГОЛ МАЛЫН ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ХҮНД, ҮНЭЛЭМЖИЙГ ӨСГӨЖ, ГАДНЫ ЗАХ ЗЭЭЛД ГАРГАХЫН ТУЛА "ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИН" ГЭСЭН ЭНЭ СИСТЕМИЙГ ГАРГАСАН ЮМ.



"ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИН" СТАНДАРТЫГ ДАГАЖ МӨРДСӨНӨӨР БИД МАЛЫНХАА ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ДЭЛХИЙН ОЛОН ХҮНД ХУДАЛДАН БОРЛУУЛНА ГЭСЭН ҮГ ААВ МИНЬ.

ХЭДЭН САРЫН ДАРАА:



